



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/48.

Улаанбаатар хот

Цагаан сарын баярын өдрүүдэд
Хариуцлагатай жижүүрээр ажиллуулах тухай


Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" А/1016 дугаар захирамж, 2020 оны "Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" А/108, "Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" А/166 дугаар захирамж, "Уриалга гаргах, халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний авах тухай" А/168 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2, 2.7-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагаан сарын баярын өдрүүдэд Улаанбаатар хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төвд "Хариуцлагатай жижүүрээр ажиллах" албан хаагчдыг Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээ түүний зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих албан тушаалтнуудаар давхар гүйцэтгүүлж, ажиллах хуваарийг хавралт ёсоор баталсугай.

2. Тушаалын хавсралтад заасан батлагдсан албан тушаалтнуудад нь Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/998 дугаар захирамжаар батлагдсан "Хариуцлагатай жижүүрээр ажиллах журам"-ыг хэрэгжүүлж ажиллахын зэрэгцээ Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд зохих хяналтыг хэрэгжүүлж, Улаанбаатар хотын шуурхай удирдлага зохицуулалтын төвд ирсэн дуудлага мэдээллийг барагдуулах, үүссэн нөхцөл байдлыг шийдвэрлэх, нийслэлийн удирдлагуудыг шуурхай мэдээллээр

ханган ажиллаж, гүйцэтгэсэн ажлын мэдээ, тайланг “Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв” ОНӨААТҮГ-т хүргүүлж ажиллахыг “Хариуцлагатай зохицуулагч” нарт үүрэг болгосугай.

3.Цагаан сарын баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүрээр ажилласан мэдээ, тайланг нэгтгэж, 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 15:00 цагаас өмнө Улаанбаатар хотын Ерөнхий менежерт танилцуулахыг Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨААТҮГ /Ч.Ган-Очир/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Дотоод хяналтын хэлтэс /Ц.Рэгзэдмаа/-т тус тус даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 02 сарын 18 өдрийн
тушаалын хавсралт



ЦАГААН САРЫН БАЯРЫН ӨДРҮҮДЭД “ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРЭЭР АЖИЛЛАХ”
ҮҮРГИЙГ САЙЖРУУЛСАН ШАХМАЛ ТҮЛШ БОЛОН ТҮҮХИЙ НҮҮРСНИЙ ХЭРЭГЛЭЭ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ АЛБАН
ТУШААЛТНУУДААР ДАВХАР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖЛЫН ХУВААРЬ

Д/д	Овог нэр	Албан тушаал	Үүрэг гүйцэтгэх он, сар, өдөр	Цагийн хуваарь	Тайлбар
1	Г.Мөнхзул	Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын дарга	2020.02.23	21.00-09.00	II/23-ны 21.00-ээс II/24-ний 09.00 цаг хүртэл.
2	Б.Бат-Эрдэнэ	Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газрын дарга	2020.02.24	09.00-09.00	24 цагаар үүрэг гүйцэтгэнэ.
3	Б.Байгалмаа	Соёлын төв өргөөний	2020.02.25		
4	Ш.Үнэнбат	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар	2020.02.26		
5	С.Эрдэнэтуул	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ	2020.02.27		